“Хөдөлмөр засал” хөтөлбөрийн боловсролын тогтвортой байдал: онолын практик хэрэглээ

С.Булганчимэг[1], С.Долгорсүрэн[1], М.Эрдэнэцэцэг[1], Б.Солонго[2], Б.Оюунгоо[1]
[1]Сувилахуйн Сургууль, АШУҮИС
[2]Анагаах Ухааны Сургууль, АШУҮИС
Цахим шуудан: bulganchimeg.s@mnums.edu.mn, Утас: 88096196

Түлхүүр үг:
Хөтөлбөрийн үнэлгээ,
хөдөлмөрт суурилсан,
онол,
хөдөлмөр засалч

Товч утга

Монгол улсад 2014 оноос эхлэн хөдөлмөр засалч мэргэжилтнийг бэлтгэх хөтөлбөрийг АШУҮИС хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2022 оны байдлаар бакалаврын зэрэгтэй 30 хөдөлмөр засалчаас гадна хөдөлмөр заслын богино хугацааны сургалтаар бэлтгэгдсэн 6 сувилагч, хөдөлмөр заслын ангийн 32 оюутан, мэргэжлийн 3 багш ажиллаж байна. Шинээр хэрэгжиж буй хөдөлмөр засалч мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийг үнэлж, хөдөлмөр засалчдын тусламж үйлчилгээний нөхцөл байдлыг тодорхойлон хөтөлбөрийг цаашид хөгжүүлэх шаардлагатай байна. Хөдөлмөр засалч мэргэжилтэн бэлтгэж буй сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж хөдөлмөр засалчдын мэргэжлийн үйл ажиллагааны нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор тус судалгааг хийв. **Судалгаанд а**налитик судалгааны агшингийн болон чанарын судалгааны загварыг ашиглан мэргэжлийн хичээлүүдийн агуулгад дүн шинжилгээ хийн үнэлж, төгсөж гарсан 26 хөдөлмөр засалч болон хөдөлмөр заслын сургалтаар бэлтгэгдсэн 6 сувилагч нарын тусламж үйлчилгээний нөхцөл байдлыг тодорхойлсон. Агшингийн судалгааны үр дүнд дүрслэх статистик боловсруулалт хийлээ. Дүрслэх феноменологийн арга ашиглан 8 хагас бүтэцтэй ярилцлага хийж үр дүнг тематик анализаар боловсруулсан. Хөдөлмөр засал хөтөлбөрийн 4 жилийн хугацаанд нийт 65 төрлийн хичээл үзэж байгаагаас 30 хичээл нь хөдөлмөр заслын мэргэжлийн хичээл байна. Хөдөлмөр заслын мэргэжлийн хичээлүүдийн 70% нь хөдөлмөрт суурилсан, 30% нь биемахбодийн алдагдал, механик парадигмын шинжийг агуулсан байна. Мэргэжлийн 26 хөдөлмөр засалч, 6 сувилагч төв болон тусгай эмнэлгүүд, тусгай хэрэгцээт цэцэрлэгт, хувийн эмнэлэг, сувилалд хөдөлмөр заслын тусламж үйлчилгээ явуулж байна. Хөдөлмөр засалч нар бүх насны хүмүүстэй ажиллаж байгаа бөгөөд танин мэдэхүйн алдагдал, төрөлхийн хөгжлийн бэрхшээл, мэдрэлийн эмгэгтэй үйлчлүүлэгчдийн тусламж үйлчилгээ үзүүлж дийлэнх хувь нь үйлчлүүлэгчийн чадвар алдагдалд чиглэсэн байна. Мэргэжлийн хичээлүүдийн агуулгын 70 хувь нь хөдөлмөрт суурилсан байгаа боловч ажиллаж буй хөдөлмөр засалчдын үнэлгээ, эмчилгээний арга нь үйлчлүүлэгчийн чадвар алдагдалд чиглэсэн уламжлалт аргаар тусламж үйлчилгээ явуулж байна.

Оршил:

Үндэслэл: Хөдөлмөр заслын дэлхийн холбооноос 2004 онд Монгол улсад хөдөлмөр засалч мэргэжилтний хэрэгцээ шаардлагыг үнэлсэн. Уг үнэлгээнээс Монгол улсад сэргээн засахын мэргэжилтнүүд хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалчдыг бэлтгэдэггүй бөгөөд эрүүл мэндийн байгууллага, төвүүд, нийгэм хамгааллын болон төрийн бус байгууллага, нийслэл, орон нутаг, бүс нутгийн аль ч түвшинд сэргээн засах тусламж шаардлагатай үйлчлүүлэгч нар тусламж үйлчилгээ авахгүй байгааг тодорхойлсон. Хөдөлмөр заслын дэлхийн холбооны (WFOT 2008) төлөөлөгч нар «Гишүүн бус орнуудад хөдөлмөр засалч мэргэжилтнийг хөгжүүлэх» баримт бичгийг төслийн багт туслах удирдамж болгон ашигласан.[1] Энэ үйл ажиллагааны хүрээнд Монгол улсад хөдөлмөр заслын салбарыг хөгжүүлэх үүргийг Цүрихийн Хэрэглээний Шинжлэх Ухааны Их Сургуульд өгсний улмаас 2007 онд ЭМШУИС-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулан, багшлах боловсон хүчнийг бэлтгэх үйл ажиллагааг эхлүүлсэн.[2] Мөн 2007 онд Япон улсын Гунма Их сургууль ЭМШУИС-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулан Хөдөлгөөн засалч мэргэжилтнийг хамтарсан хөтөлбөрийн хүрээнд бэлтгэж эхэлсэн ба Хөдөлмөр засалч мэргэжилтэн бэлтгэх бакалаврын хөтөлбөрийг боловсруулж багшлах боловсон хүчнийг чадавжуулах ажлыг 2012 оноос эхэлсэн. АШУҮИС-ийн Сувилахуйн сургууль нь 2014 оноос эхлэн хөдөлмөр заслын бакалаврын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэн анхны 6 хөдөлмөр засалч мэргэжилтэн 2018 онд төгссөн бөгөөд 2022 оны байдлаар 30 хөдөлмөр засалч, хөдөлмөр заслын сургалтаар бэлтгэгдсэн 6 сувилагч, хөдөлмөр заслын ангийн 32оюутан, мэргэжлийн 3 багш ажиллаж байна. Шинээр хэрэгжиж буй хөдөлмөр засалч мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийг үнэлж, хөдөлмөр засалчдын тусламж үйлчилгээний нөхцөл байдлыг тодорхойлон хөтөлбөрийг цаашид хөгжүүлэх шаардлагатай байна.

Судалгааны ажлын ач холбогдол: **Энэхүү** судалгааг хийснээр хөдөлмөр засалчдын үзүүлж буй тусламж үйлчилгээний нөхцөл байдал, онол практикийн хэрэглээг бодит байдал дээр тодорхойлно. Хөдөлмөр засалч мэргэжилтний ажиллах чиглэлүүдийг тодорхойлсноор салбарын шийдвэр гаргагчид, удирдлагуудад хүний нөөц, тусламж үйлчилгээний талаар бодлого боловсруулахад үндэс болохуйц мэдээллээр хангана.

Хөдөлмөр заслын хөгжлийн парадигмуудын тухай

XX зууны эхэнд өвчний эдгэрэлт болон чадвар алдалтад дасан зохицоход хөдөлмөрийг ашиглах замаар хөдөлмөр засал анх үүсч байсан. Хөдөлмөр заслын хөгжлийн дунд үе буюу 1950-аас 1980-аад оны хооронд анагаах ухааны хөгжлийн шинэ ойлголтуудын нөлөөнд хөдөлмөр заслын тусламж үйлчилгээний гол зарчим өөрчлөгдөж эмчилгээний үйл явцыг мэдрэл, сэтгэц болон бие махбодын дотоод механизмаар тайлбарлаж чадвар алдалтыг шийдвэрлэхэд хөдөлмөр заслын эмчилгээ чиглэх болсон. Харин сүүлийн 30 жилийн хугацаанд хөдөлмөрт суурилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглүүлэх хэд хэдэн загварыг эрдэмтэд гаргасан. Эдгээр загварууд нь хөдөлмөрөөр дамжуулан үйлчилгээ үзүүлэх орчин үеийн онолыг санал болгодог.[4] Хүн амьдралынхаа янз бүрийн үе шатуудад олон төрлийн үүрэг гүйцэтгэхэд утга учиртай хөдөлмөр чухал хэрэгцээ болдог гэсэн үзэл нь хөдөлмөр заслын гол философи юм.[5]

Хөдөлмөр заслын онолыг хэрхэн практикт хэрэглэх вэ?

Хөдөлмөр засалч нар онолыг хэрхэн ашигладаг талаар нарийвчлан судалсан судалгаа олон байдаг. Жишээ нь сэтгэцийн эмгэгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хөдөлмөр засалч нарын дунд хийсэн судалгаагаар хүний хөдөлмөрийн загварын цогц арга барилыг хөдөлмөр засалчид үнэлж, практик үйл ажиллагаандаа бусад загваруудыг хялбархан нэгтгэсэн гэж дүгнэжээ. Энэхүү судалгааны гол үр дүн нь хөдөлмөр засалчид онолын үзэл баримтлалыг хэрэглэх үед үйлчлүүлэгчдийнхээ онцлог, нөхцөл байдалд тохируулан ашигладагийг харуулж байв. Хөдөлмөрт суурилсан онолыг практик үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг хөдөлмөр засалчдад уриалж байгаа тул онолыг хэрхэн сонгож, бодож, практиктаа хэрэгжүүлэх талаар илүү сайн ойлголттой байх нь чухал юм. Иймд онолын хэрэглээг нэмэгдүүлэх хүчин чармайлтыг тодорхойлж, онол, түүнийг хэрэгжүүлэх арга хэрэгслийг боловсруулахад чиглүүлэх боломжтой юм.[7]

Хөтөлбөрийн үнэлгээ ба төгсөгчид

Мэргэжилтэн бэлтгэж буй хөтөлбөрт үнэлгээ хийх нь сургалтын хөтөлбөрөө хэрхэн сайжруулах талаар хөтөлбөрөөс авч байгаа мэдээлэл бөгөөд хөтөлбөрийн талаарх оюутан, төгсөгч, багш нар болон бусад оролцогч талуудын үнэлгээ, санал хүсэлт нь хөтөлбөрийн чанарыг сайжруулахтай холбоотой байдаг.[8-9] Үр дүнд суурилсан боловсролын гол зорилго нь олон улсын боловсролын стандарт болон хөдөлмөрийн зах зээлд тохирохуйц сайн бэлтгэгдсэн, дэлхийд өрсөлдөх чадвартай төгсөгчдийг төрүүлэх явдал юм.

Төгсөгчдийн дунд судалгаа явуулах нь хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарыг тодорхойлж хөтөлбөрийг цаашид улам боловсронгуй болгох арга замд чиглүүлнэ гэсэн таамгийг бид дэвшүүллээ. Хөтөлбөрт дүн шинжилгээ хийх шаардлагатай гэж үзээд хөтөлбөрийг үнэлж төгсөгчидтэй хийсэн асуумж судалгааны үр дүнг гүнзгийрүүлэн судлах зорилгоор ярилцлага хийлээ. Бидний энэхүү судалгааны зорилго нь хөдөлмөр

засалчид онолыг практик үйл ажиллагаандаа хэрэглэхийг хэрхэн ойлгож, ашигладаг талаар тайлбарлах, түүнийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлох явдал юм.


Судалгааны арга зүй: Судалгааг тоон болон чанарын судалгааны загварыг ашиглан явуулсан. Хөдөлмөр засал хөтөлбөрийн 65 хичээлийн хөтөлбөрт баримтын анализ хийсэн. Стаблибиэм (2007) нарын боловсруулсан сургалтын хөтөлбөрийн үнэлгээний батлагдсан загвар болох CIPP-г[10] ашиглан 26 төгсөгч, 6 сувилагчаас асуумж авсан. Хөдөлмөр засалчдаас 56 асуултыг 1 (огт санал нийцэхгүй)-ээс 5 (бүрэн нийцнэ) хүртэл оноогоор Google form ашиглан авсан. Асуумжийн бүлэг тус бүрийн дотоод найдвартай байдлыг Кронбах альфагаар шалгахад 0,9>α≥0,8 байлаа. Хөтөлбөрийн үр дүн буюу product-ын тусламж үйлчилгээтэй хамааралтай асуултад боловсруулалт хийсэн. Статистик боловсруулалтын SPSS 21 программ ашиглан дүнг дүрслэх статистикийн аргаар боловсруулав.

Асуумж судалгааны үр дүнг гүнзгийрүүлэн судлах зорилгоор 8 оролцогчдыг хамруулан феноменологийн аргаар, ярилцлагын удирдамжийн дагуу хөдөлмөр засалчдын өдөр тутмын практик үйл ажиллагааны талаар нээлттэй асуулт асууж, ганцаарчилсан хагас чөлөөт ярилцлагыг 40-55 минутын хугацаанд хийж дуу хураагуурт хурааж авсан. Бичлэгийг хэд дахин сонсож, үгчлэн бичиж тематик (Stanley, 2015) анализ хийсэн.[11] Эхлээд ойролцоо утга ойлголтуудыг кодолж, төрөлжүүлэн ангилсан. Чанарын судалгааны уламжлалын дагуу эдгээр төрөлжүүлэн ангилсан утгуудыг системтэйгээр нарийн нямбай тогтоосон.

Судалгааны ёс зүй: «Үр дүнд суурилсан сургалтын загвар боловсруулж, мэргэжлийн хөгжлийн ерөнхий зураглалыг тодорхойлсон нь (Хөдөлмөр засал хөтөлбөрийн жишээн дээр)” сэдэвт судалгааны ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг 2020 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн №2020/3-05 тоот АШУҮИС-ийн Судалгааны Ёс зүйн Хяналтын Хорооны хурлын шийдвэрээр авсан.

Үндсэн хэсэг: Судалгааны үр дүн

“Хөдөлмөр засал” хөтөлбөрийн 2016 онд батлагдсан сургалтын төлөвлөгөөгөөр сургалтын үйл ажиллагааг эрхлэн явуулж байна. Тус төлөвлөгөө нь хөдөлмөр засалч мэргэжилтний бакалаврын боловсрол эзэмшүүлэх зорилго бүхий 122 багц цагийн багтаамжтай сургалтын төлөвлөгөөнд тусгасан ерөнхий эрдмийн, мэргэжлийн суурь ба мэргэшүүлэх хичээл тус бүрээр суралцагчдын эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлагын агуулга, үнэлгээ, хичээлийн багтаамж, ашиглавал зохих ном сурах бичгийн жагсаалтыг агуулсан тодорхойлон заасан баримт бичиг юм. Нийт 65 хичээлийн хөтөлбөрт дүн шинжилгээ хийхэд 30 (46%) хөдөлмөр заслын мэргэжлийн хичээлүүд байна. Эдгээр мэргэжлийн хичээлүүдийг задалж үзвэл 70% нь хөдөлмөрт суурилсан онолын хичээлүүд, 30% нь чадвар алдалтанд чиглэсэн байна.



Зураг 1. “Хөдөлмөр засал” хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээ

Судалгаанд тус хөтөлбөрөөр төгссөн 26, сувилагч 6, нийт 32 хөдөлмөр засалч хамрагдсан. Хүснэгт 1-д ерөнхий мэдээллийн үзүүлэлтүүдийг оруулаа.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

	Бүлэг		Нас		Хүйс	
Дамжаа/ Төгсөлт N		(%)	Насны бүлэг	(%)	Хүйс	Тоо (%)
Төгсөгч 2020 (4) 2019 (10)	2021 (7)	22%	20-25	81%	Эрэгтэй	6%
	12%					
	31%					
	2018 (5)	16%			Эмэгтэй	94%
Сувилагч ОТ		19%	38-50	19%		

Судалгаанд оролцогчдын 81 хувь нь 20-25, 19 хувь нь 38-50 настай, 6 хувь нь эрэгтэй 94 хувь нь эмэгтэй хүн эзэлж байв.



Зураг 2. Хөдөлмөр засалчдын үзүүлж буй тусламж үйлчилгээ

Хөдөлмөр засалч нар өдөр тутмын практик үйл ажиллагаандаа 83,3% нь танин мэдэхүйн алдагдал, 72,2% нь төрөлхийн хөгжлийн эмгэг, 66.7% нь мэдрэлийн эмгэгтэй хүмүүст хөдөлмөр заслын эмчилгээг хийж байна. Харин сэтгэцийн эмгэг, түлэгдэлт, зүрх судасны эмгэгийн үеийн тусламж үйлчилгээ хамгийн бага байна.

Ярилцлагад оролцогчдын нас, ажил эрхлэлт, боловсролын байдал, ажилласан жилийн тухай мэдээллийг Хүснэгт 2-т харуулсан байна.

Хүснэгт 2. Ярилцагад оролцогчдын мэдээлэл

Оролцогчид	Нас	Ажил эрхлэлт	Боловсрол	Ажилласан жил
Оролцогч 1	23	Хүүхэд	4 жил, бакалавр	2 жил
Оролцогч 2	24	Хүүхэд	4 жил, бакалавр	2 жил
Оролцогч 3	23	Мэдрэл, хүүхэд	4 жил, бакалавр	1 жил
Оролцогч 4	23	Мэдрэл, хүүхэд	4 жил, бакалавр	1 жил
Оролцогч 5	38	Хүүхэд	4 жил, БТ-ын арга зүйч 6 д/х ОТ	8 жил
Оролцогч 6	43	Хүүхэд	Сувилагч + 6 д/х ОТ	8 жил
Оролцогч 7	49	Мэдрэл, хүүхэд	Сувилагч + 1 сар ОТ Солонгос улс	9 жил
Оролцогч 8	40	Мэдрэл	Сувилагч + 6 сар ОТ Энэтхэг улс	6 жил

Найман оролцогч тус бүртэй ганцаарчлан хийсэн ярилцлагыг кодолж, төрөлжүүлэн ангилсныг хүснэгт 3-аар харуулав. Энэ ангиллаас “Онол бол практикт чухал биш”, “Монголын хөдөлмөр засалчид гарын нарийн нийлмэл үйл ажиллагаа, чадвар алдалтыг сайжруулахад чиглэн ажилладаг”, “Хөдөлмөр заслын талаарх бусад хүмүүсийн мэдлэг чухал” гэсэн 3 үндсэн санаа (themes) илрэв.

Хүснэгт 3. Ярилцлагын төрөлжүүлсэн утгууд

- Бодит байдал дээр онол шаардлагагүй.
- Хөдөлмөр засалч дээд мөчдийн үений далайцийг сайжруулах ёстой.
- Хөдөлмөр засалчийн гол зорилго нь гарны хөдөлгөөнийг сайжруулах.
- Хүүхэд уйлж байсан ч дасгалаа хийнэ.
- Боловсролын багш нар л тоглоомын өрөөнд хүүхэдтэй ажиллана.
- Ажил олгогчид бусад ажилтнууд хөдөлмөр засалчийн тухай сайн мэддэггүй ч тэр байдлаа хүлээн зөвшөөрдөггүй.
- Хөдөлмөр засалчид зөвхөн стандарт үнэлгээ хэрэглэнэ.
- Эмчийн зааснаар хөдөлмөр засалчид ажиллах ёстой.
- Хөдөлмөр засалч удирдлаган дор ажиллах ёстой.
- Хөдөлмөр засалч үйлчлүүлэгчтэй 3-5 удаа тусламж үзүүлж байна.
- Ажиллах орчин, тоног төхөөрөмж, хэрэгсэл сайн хангагдаагүй.
- Эмчилгээний үргэлжлэх хугацаа нь онолын дагуу ажиллахад хангалтгүй юм.
- Гадаадын сайн дурын ажилтны зөвлөснийг дагах ёстой.
- Монгол хэл дээр орчуулсан хөдөлмөр заслын үнэлгээнүүд байдаггүй.

Хэлцэмж: Хөдөлмөр засалчдын практик үйл ажиллагааны үзэл бодлыг сонсоход хөдөлмөр засал хөтөлбөрийн бодит байдал дээрх хэрэгжилтийн талаарх сонирхолтой үр дүн харагдсан. Мэргэжлийн хичээлийн агуулгын 70% нь хөдөлмөрт суурилсан, онолын хичээлүүд байгаа хэдий ч онол бол практикт чухал биш гэж хөдөлмөр засалч нар үзэж байв. Харин Икиугу нарын судалгаагаар[12] онолын хэрэглээний ур чадвар нь оюутнууд өөрсдийгөө хөдөлмөр заслын үнэлгээ, эмчилгээнд ур чадвартай гэж бодоход нөлөөлдөг гэжээ. Судалгаанд оролцогчдын үзүүлдэг хөдөлмөр заслын тусламж үйлчилгээ нь гол төлөв дээд мөчдийн үйл ажиллагааг сайжруулан, чадвар алдалтыг бууруулахад чиглэж байв. Хөдөлмөрт илүү төвлөрч, нотолгоонд суурилсан практик үйл ажиллагаа явуулснаар хөдөлмөр засалч нар ихээхэн амжилтанд хүрсэн гэсэн нотолгоо бий. Үүний тулд цахим болон танхимын хэлбэрээр төгсөлтийн дараах төрөл бүрийн сургалтыг зохион байгуулж онол практикийн уялдаа холбоог сайжруулах шаардлагатай талаар Лий нарын[4] судлаачид зөвлөсөн байна.

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй хүмүүст сэргээн засахын асуудлуудыг тусгасан хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, стратеги зайлшгүй шаардлагатай.[13] Олон нийтэд танигдсан, бие даасан мэргэжил болохын тулд зорилго, хүсэл эрмэлзэл, сонирхлоо нээлттэй болгож ямар үйлчилгээ үзүүлж чадах, юу хийхийг хүсч байгаагаа ил тод болгох хэрэгтэй гэж судлаачид үзэж байгаатай[14] Монголын хөдөлмөр засалчид санал нэг байна. Үүнийг судалгаанаас илэрсэн “Хөдөлмөр заслын талаарх бусад хүмүүсийн мэдлэг чухал” гэсэн санаа харуулж байна.

Дүгнэлт: Хөдөлмөр заслын мэргэжлийн хичээлийн дийлэнх нь хөдөлмөрт суурилсан хичээл байна. Практик үйл ажиллагаанд хөдөлмөр заслын онолын хэрэглээ бага түвшинд байна. Хөдөлмөр засалчид үйлчлүүлэгчийн чадвар алдалтад анхаарч үнэлгээ, эмчилгээнд доороос дээш чиглэсэн (bottom-up approach) аргыг голчлон ашигладаг. Удирдлага болон хамтран ажиллагсдын хөдөлмөр заслын талаарх мэдлэг нь хөдөлмөр засалчдын өдөр тутмын практик үйл ажиллагаанд нөлөөлж байна.

Ном зүй

1. Mentrup C. Mongolia: A Country without Therapy Services. World Federation of Occupational Therapists Bulletin.; 2006. 53:1, 55-56.
2. Langlotz Kondzic V., Mentrup C., Oidov V., Erdenetsetseg., Applying strategical planning in the development of Occupational Therapy in Mongolia – lessons learnt and future implications 2016, 15th-19th June, COTEC- ENOTHE 2016
3. Morante D. Occupational therapy emerging in Mongolia: a case study. World Federation of Occupational Therapists Bulletin. 2017;73(2):88-93.
4. Lee SW, Taylor R, Kielhofner G, Fisher G. Theory use in practice: a national survey of therapists who use the Model of Human Occupation. The American Journal of Occupational Therapy. 2008;62(1):106-17.
5. Salvatori P. Meaningful occupation for occupational therapy students: a student-centred curriculum. Occupational Therapy International. 1999;6(3):207-23.
6. Mucoz JP, Lawlor M, Kielhofner G. Use of the model of human occupation: A survey of therapists in psychiatric practice. The Occupational Therapy Journal of Research. 1993;13(2):117-39.
7. Taylor RR. Kielhofner’s research in occupational therapy: Methods of inquiry for enhancing practice: FA Davis; 2017.
8. Honorat D. Curriculum Evaluation of FSRL: An Occupational Therapy Program in Haiti. 2018.
9. Carnell B, Fung D. Developing the higher education curriculum: Research-based education in practice: UCL Press; 2017.
10. Aziz S, Mahmood M, Rehman Z. Implementation of CIPP Model for Quality Evaluation at School Level: A Case Study. Journal of Education and Educational Development. 2018;5(1):189-206.
11. Stanley M. Qualitative descriptive: A very good place to start. Qualitative research methodologies for occupational science and therapy: Routledge; 2014. p. 37-52.
12. Ikiugu MN, Smallfield S. Instructing occupational therapy students in use of theory to guide practice. Occupational Therapy in Health Care. 2015;29(2):165-77.
13. Galheigo SM. Occupational therapy and the social field: clarifying concepts and ideas. Occupational therapy without borders: learning from the spirit of survivors. 2005:87-98.

Sustainability of Occupational therapy education in Mongolia: Usage of theory in practice

Bulganchimeg.S[1], Erdenetsetseg.M[1], Dolgorsuren.S[1]
Solongo.B[2], Oyungoo.B[1]
School of Nursing, MNUMS[1]
School of Medicine, MNUMS[2]
E-mail: bulganchimeg.s@mnums.edu.mn , Tel: 88096196

***Key words**:*

Curriculum evaluation, occupational therapy

INTRODUCTION. Introducing the new profession is a big challenge for those who are employed to be in charge of developing the educational programme and teach the theory and therapeutic skills for occupational therapy students. Following the WFOT advice for the establishment of a new programme for the education of occupational therapists, in order to develop the curriculum, we had an extensive network and partnership with an established and WFOT approved schools such as ZHAW, Gunma University and HvA. As a part of the evaluation of the curriculum this study examines the compliance of taught theory and its use in practice. METHOD. Quantitatшce and Qualitative research design was used in this study. This study used a detailed questionnaire to analyze contents of theories in all 65 subjects taught for occupational therapy students during four-year study and also six occupational therapist and six nurse practitioners working as occupational therapists were surveyed as to what theories they use in their practice. 8 semi-structured interviews were conducted using descriptive phenomenological methods and the results were analyzed by thematic analysis RESULTS. Approximately 70% of taught theories are occupation-focused and 30% are from different frames of reference. However, practitioners predominantly use assessments and interventions focused to clients’ impairments. CONCLUSION. The newly established profession of occupational therapy in Mongolia has not yet embraced the contemporary paradigm and tends to avert to mechanical paradigm.